

“ЗЭЭЛ ЭМ ЭН ПЛАТФОРМ ББСБ” ХХК-ИЙН ЧАНАРЫН БОДЛОГО

1. Чанарын бодлого

1.1. Бид цахим ногоон гүүр байж үйл ажиллагаагаа олон улсын стандартад нийцүүлэн тасралтгүй сайжруулан ажиллана.

- Цахим: Технологийн дэвшлийг соргогоор үйл ажиллагаандаа тасралтгүй нэвтрүүлэн ажиллана. Тогтсон уламжлалт процессийг эвдэн хялбар, нөөцийг хэмнэсэн, цахим аргачлалд шилжүүлэх нь бидний чиглэл байна.
- Ногоон: Бидний бизнес ашигт бус үнэ цэнд чиглэнэ. Ингэхдээ эрүүл хамтрагчидтай хамтран ажиллаж холбогдох хуулийн дагуу үйл ажиллагааг явуулна.
- Гүүр: Хөрөнгө оруулагч болон зээлдэгчийг уулзуулах итгэлцлийг авчрах платформ байна.

1.2. Чанарын бодлогыг өөрчлөх эсэх талаар удирдлагууд жилдээ нэг удаа хянана.

2. Чанарын бодлогыг хэрэгжүүлэхэд дараах үндсэн зорилтыг удирдлага болгон ажиллана. Үүнд:

2.1. Харилцагч болон технологийн түншүүд, гуравдагч байгууллагатай хамтран ажиллахдаа үргэлж шинэ боломж, нөхцөлийг бий болгож ажиллана.

2.2. Нийгмийн болон санхүүгийн гадаад, дотоод нөхцөл байдлыг үйл ажиллагаандаа тогтмол тусган өөрчлөлтөд нээлттэй байна.

2.3. Бизнесийн болон өрх гэрийн амьдралд бодитой хувь нэмэр оруулсан, Монгол улсын үлгэр жишээ байгууллага болно.

2.4. Байгууллагын зорилго, зорилт, төлөвлөлтийг Олон Улсын чанарын удирдлагын тогтолцооны (ISO 9001:2015) стандарт болон Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу хэрэгжилтийг хангаж ажиллана.

- 2.5. Хувьсан өөрчлөгдөх хэрэглэгчийн шаардлага, байгууллагын гадаад болон дотоод хүчин зүйлийн нөлөөлөлд дүн шинжилгээ хийж өгөгдөлд суурилсан шийдвэр, шийдэл боловсруулан чанарын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулах замаар байгууллагын төгөлдөршлийг хангаж ажиллана.
- 2.6. Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, чанарын удирдлагын тогтолцооны үр нөлөөг тасралтгүй сайжруулна.
- 2.7. Чанарын үзүүлэлт, бизнесийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээний чанараа тогтмол сайжруулан ажилласнаар хэрэглэгчдийн шаардлагыг хангаж, улмаар давуулан биелүүлнэ;
- 2.8. Гадаад болон дотоод сонирхогч талуудынхаа хүлээлт шаардлагад мэдрэмжтэй хандаж, ил, тод, нээлттэй, хүртээмжтэй эргэх холбоо бүхий харилцааг сахиулж үнэ цэнийг бий болгоно.
- 2.9. Инновацид тулгуурласан шилдэг техник, технологийг нэвтрүүлэхэд салбартаа тэргүүлэгч байна.
- 2.10. Ажилтнуудын ур чадварыг байнга хөгжүүлж, мэргэжлийн өндөр түвшинд үйл ажиллагаа явуулна.
- 2.11. Үйл ажиллагаандаа байгаль орчинд ээлтэй арга, техник технологийн нэвтрүүлэхийг зорьж, сөрөг нөлөөллийг бууруулах бүтээлч санал санаачлагыг дэмжиж ажиллана.
- 2.12. Энэхүү үүрэг амлалт нь байгууллагын үнэт зүйлстэй нэгтэй бөгөөд бидний тасралтгүй хөгжил ба амжилтын үндэс байх болно